



## ГОМБОДОНОЙН ДАМДИН

Улаанбаатар хотын захиргааны дарга  
1941.07-1941.08

Хуучин Хан-Хэнтий уулын аймгийн Оцолсансар уулын хошуу, одоогийн Дорноговь аймгийн Их-Эрээн сум /1942 онд Дундговь аймагт шилжээд 1952 онд татан буугдсан/ -ын нутагт 1906 онд төрсөн.

1924 онд МАХН-ын гишүүнд элссэн. 1922-1924 онд Оцолсансар уулын хошууны тамгын газар бичээч, 1924 онд Намын сургууль анх байгуулагдахад орж, уг сургуулиа төгсөөд Хантайшир уулын хошуунд Залуучуудын эвлэлийн сургагч, дараа нь Дорноговь аймгийн намын хорооны даргаар 1931, 1934 онд хоёр удаа ажиллаж, 1938 оноос Увс аймгийн хоршоодын холбооны дарга, 1940 оны тавдугаар сараас Улаанбаатар Хотын захиргааны орлогч дарга,

1941 оны дол дугаар сарын 18-наас 1941 оны наймдугаар сарын 25 хүртэл хотын захиргааны даргаар нэг сар гаруй хугацаанд ажиллажээ. Г.Дамдин МАХН-ын IX, улсын VIII их хуралд төлөөлөгчөөр оролцож, МАХН-ын Төв Хорооны гишүүнээр сонгогдож байв.

Г.Дамдингийн хөдөлмөр бүтээлийг үнэлж “Хөдөлмөрийн гавьяаны одон”, Ардын хувьсгалын 15 жилийн ойн хүндэт тэмдгээр шагнасан бөгөөд 1933 онд Октябрийн хувьсгалын ойн баярт оролцох Монголын

төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж ЗСБНХУ-д очсон байна. Тэрээр “Говийн хүүхэн Гүндэгмаа” гэдэг драмын жүжгийн зохиол бичиж, 1930 онд өөрөө оролцон тоглож байсан нь тэр үедээ хот хөдөөд нэлээд дэлгэрч байсан билээ. Хотын захиргааны даргаар ажиллаж байхад нь 1941 оны 8 дугаар сарын 25-нд хилс хэрэгт холбогдуулан баривчилсан бөгөөд хожим 1964 оны есдүгээр сарын 10-ны өдөр Дээд шүүхийн 47 дугаар тогтоолоор цагаатгажээ.

РйДЕщ1^^Ет1^1^^<лгД1лгЗС Ө.Мажиг